**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр | Дугаар А/59 А/203 | Улаанбаатар хот

**Монгол Улсын визийн загвар батлах тухай**

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.15, 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг, "Журам батлах тухай" Засгийн газрын 2021 оны 192 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын виз олгох журам"-ын 7.6, 10.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын визийн хуудасны загварыг нэгдүгээр, визийн хуудсанд тэмдэглэх мэдээллийг хоёрдугаар, цахим визийн загварыг гуравдугаар, цахим визэд тэмдэглэх мэдээллийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Анхбаяр/, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/ нарт даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Монгол Улсын визийн загварыг батлах тухай" Гадаад хэргийн сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/28, А/55 дугаар хамтарсан тушаал, "Загвар батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын А/145, А/66 хамтарсан тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

1119287523 ШТТ6740 9131817

Гадаад харилцааны сайд,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны 09 дүгээр сарын 06.-ны өдрийн A/50/A103 дугаар
хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

1119287523 ШТТ6740 9131817

MONGOLIA MNG 0191749

0191749

MONGOLIA MNG 0191749

MONGOLIA

MNG 0191749

*Гадаад харилцааны сайд,*
*Хууль зүй, дотоод хэргийн сайдын*
*2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/51/А/203 дугаар*
*хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт*

# ВИЗИЙН ХУУДСАНД ТЭМДЭГЛЭХ МЭДЭЭЛЭЛ

1. Монгол Улсын визийн хуудас нь 7*11 см хэмжээтэй байна.

2. Хуудасны дээд хэсэгт “MONGOLIA” гэсэн бичиг байна.

3. Хуудасны баруун дээд буланд “MNG” гэсэн бичвэрийн ард 7 оронтой дугаар байна.

4. Хуудасны зүүн дээд буланд Монгол Улсын төрийн сүлдийг байрлуулна. Төрийн сүлд нь нууцлалын хувирдаг өнгөтэй байна.

5. Хуудасны гол хэсэгт Монгол Улсын газрын зургийг дүрсэлж дэвсгэр хийнэ. Голд нь Соёмбо байрлуулах бөгөөд энэ нь тусгай төхөөрөмжөөр өнгө ялгарах нууцлалтай байна.

6. Хуудасны баруун гол хэсэгт 3*4 см хэмжээтэй цээж зураг байрлуулах зай байна.

7. Визийн хуудсан дээр дараах мэдээллийг монгол, англи хэлээр бичсэн байна.

   7.1. Бүртгэлийн дугаар / ID number
   7.2. Овог, нэр / Full name
   7.3. Иргэний харьяалал / Citizenship
   7.4. Паспортын дугаар /Passport number
   7.5. Визийн хуудасны дугаар
   7.6. Визийн ангилал / Visa category
   7.7. Визийн төрөл / Type of visa
   7.8. Виз олгосон огноо /Date of issue
   7.9. Визийн зориулалт /Entries
   7.10. Визийн хүчинтэй хугацаа /Enter before
   7.11. Виз олгосон газар /Issued at
   7.12. Тусгай тэмдэглэл /Remarks

8. Визийн хуудас нь машинаар уншигдах хэсэгтэй байна.

---o0o---

Гадаад харилцааны сайд,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн A/501/A/203 дугаар
хамтарсан тушаалын гуравдугаар хавсралт

1119287523 ШТТ8740 9131817

# МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ ВИЗИЙН ЗАГВАР

**MONGOLIA**
**Electronic Visa**

www.evisa.mn



ID 9911122314

| | |
|---|---|
| Surname: *Овог* | MICHAEL KEMSKY |
| Name: *Нэр* | JOHN |
| Date of birth: *Төрсөн огноо* | 20-Jun-1970 |
| Gender: *Хүйс* | MALE |
| Nationality: *Иргэний харьяалал* | HUNGARY |

Passport information

| | |
|---|---|
| Passport number: *Паспортын дугаар* | YU012358987 |
| Passport type: *Паспортын төрөл* | Ordinary |
| Date of expiry: *Дуусах хугацаа* | 18-Mar-2025 |

E-Visa number MNG0191609

E-Visa information

| | | | |
|---|---|---|---|
| Visa category: *Визийн ангилал* | K2 | Date of issue: *Олгосон огноо* | 29-Apr-2021 |
| Number of entries: *Визийн төрөл* | SINGLE | Enter before: *Хүчинтэй хугацаа* | 30-Sep-2021 |
| Type of visa: *Визийн зориулалт* | ENTRY | Duration of stay: *Байх хугацаа* | 30 days |

***Notes:***

- *The validity of this e-visa can be verified by QR code or online at www.evisa.mn*
- *In case that the records in your e-visa and passport differ, your e-visa will be considered invalid.*
- *In exceptional circumstances, it is possible that relevant authorities may refuse your entry to Mongolia.*
- *During your stay in Mongolia you are obliged to comply with the laws and regulations of Mongolia.*
- *Your biometric details are required to be provided at the border control office at the time of your arrival.*
- *You are required to be registered online within 48 hours after your arrival through www.immigration.gov.mn.*
- *Enjoy your visit to Mongolia and please do not exceed the duration of your visa so that we can welcome you again!*

Contact us: +976 -1800-1882, info@evisa.mn, www.immigration.gov.mn, Immigration Agency of Mongolia, Government Implementing Agency, Ulaanbaatar, Mongolia

Гадаад харилцааны сайд,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн A/150/A/203 дугаар
хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралт

# ЦАХИМ ВИЗИЙН ХУУДСАНД ТЭМДЭГЛЭХ МЭДЭЭЛЭЛ

1. Монгол Улсын цахим визийн хуудас нь 297*210 мм хэмжээтэй байна.

2. Хуудасны зүүн дээд хэсэгт Монгол Улсын төрийн сүлдийг байрлуулсан байна.

3. Монгол Улсын төрийн сүлдний ард "MONGOLIA" гэсэн бичвэрийг 14 хэмжээтэй, "ELECTRONIC VISA" гэсэн бичвэрийг 12 хэмжээтэй хоёр мөрөнд багтаан бичсэн байна.

4. Хуудасны баруун дээд буланд Монгол Улсын газрын зураг байрлах бөгөөд түүний дор www.evisa.mn гэсэн хар хөх өнгийн бичвэр байна.

5. Хуудасны дээд хэсэгт Монгол Улсын онцлогийг харуулсан дэвсгэр зургууд байрлана.

6. Цахим визэд дараах үндсэн мэдээллийг монгол, англи хэлээр бичсэн байна.
   - 6.1. Бүртгэлийн дугаар
   - 6.2. Овог
   - 6.3. Нэр
   - 6.4. Төрсөн огноо
   - 6.5. Хүйс
   - 6.6. Иргэний харьяалал
   - 6.7. Паспортын дугаар
   - 6.8. Паспортын төрөл
   - 6.9. Паспортын дуусах хугацаа
   - 6.10. Цахим визийн дугаар / "MNG" гэсэн бичвэрийн ард 7 оронтой тоо байна./
   - 6.11. Цахим визийн QR код
   - 6.12. Визийн ангилал
   - 6.13. Визийн төрөл
   - 6.14. Визийн зориулалт
   - 6.15. Виз олгосон огноо
   - 6.16. Визийн хүчинтэй хугацаа

6.17. Байх хугацаа
6.18. Санамж

"NOTES
· The validity of this e-visa can be verified by QR code or online at www.evisa.mn
· In case that the records in your e-visa and passport differ, your e-visa will be considered invalid.
· In exceptional circumstances, it is possible that relevant authorities may refuse your entry to Mongolia.
· During your stay in Mongolia you are obliged to comply with the laws and regulations of Mongolia.
· Your biometric details are required to be provided at the border control office at the time of your arrival.
· You are required to be registered online within 48 hours after your arrival through www.immigration.gov.mn.
· Enjoy your visit to Mongolia and please do not exceed the duration of your visa so that we can welcome you again!"

7. Хуудасны доод хэсэгт *"Contact us: +976 -1800-1882, info@evisa.mn, www.immigration.gov.mn, Immigration Agency of Mongolia, Government Implementing Agency, Ulaanbaatar Mongolia"* гэсэн бичвэр байна.

8. Цахим визийн хуудсанд тэмдэглэх мэдээлэл нь Arial үсгийн фонттой байна.

---o0o---